



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 02 өдөр

Дугаар А/309

Номгон

Г "Хонгорын гэр бүл" арга хэмжээний хэрэглэгдэхүүн бэлтгэхэд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.1 дэх заалт, Баянхонгор аймгийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн 1.2.1 дэх заалт, аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.6.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн 2023 оны Хөгжлийн төлөвлөгөөний бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг хангах 6.1.3 дахь заалтын задаргаа төлөвлөгөөний 11 дүгээрт тусгагдсан "Хонгорын гэр бүл" зорилтот арга хэмжээний 2022-2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор модульт сургалтуудыг зохион байгуулсугай.

2. Сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулахад зарцуулах 5.000.000 (Таван сая) төгрөгийг аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардлаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Байгалмаа)-д зөвшөөрсүгэй.

3. Төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (В.Наранчимэг)-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавиж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхжаргал) д ааалгасугай.


ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

642310773

Аймгийн Засаг дарга... оны... дугаар
сарын... нь Г.Ө.Д.И.Н... дүгээр
захирамжийн хэвсрэлт



"ХОНГОРЫН ГЭР БҮЛ" ЗОРИЛТОТ АРГА ХЭМЖЭЭНИЙ
2022-2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД
ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт дүн
1	Модуль 1. Гэрлэлт, гэр бүлийн тухай ойлголт сэдвээр үзүүлэн бэлтгэх	5ш	100.000	500.000
2	Модуль 2. Гэр бүл төлөвлөлт сэдвээр үзүүлэн бэлтгэх	5ш	100.000	500.000
3	Модуль 3. Угийн бичиг хөтлөх арга зүй сэдвээр үзүүлэн бэлтгэх	5ш	100.000	500.000
4	Модуль 4. Гэр бүлийн харилцаа сэдвээр үзүүлэн бэлтгэх	5ш	100.000	500.000
5	Модуль 5. Гэр бүл дэх хүүхдийн хүмүүжил сэдвээр үзүүлэн бэлтгэх	5ш	100.000	500.000
6	Модуль 6. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нь сэдвээр үзүүлэн бэлтгэх	5ш	100.000	500.000
7	Модуль 7. Гэр бүлийн эрүүл мэнд сэдвээр үзүүлэн бэлтгэх	5ш	100.000	500.000
8	Модуль 8. Өрхийн төсөв сэдвээр үзүүлэн бэлтгэх	5ш	100.000	500.000
9	Хэрэглэгдэхүүн	1 багц	1.000.000	1.000.000
Нийт 5.000.000 төгрөг				

оОо